

# МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН 2004 ОНЫ ШҮҮН ТАСЛАХ АЖЛЫН НЭГДСЭН ДҮНГИЙН ТУХАЙ.

## НЭГ. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮН ТАСЛАХ АЖЛЫН ТАЛААР

Монгол улсын шүүхүүд 2004 онд 11695 холбогдогчтой эрүүгийн 7443 хэрэг хүлээн авч, 757 холбогдогчтой 374 хэргийг урьдчилсан мөрдөн байцаалтад буцааж, 711 холбогдогчтой 341 хэргийг хэрэгсэхгүй болгож, 9473 холбогдогчтой 6272 хэргийг таслан шийдвэрлэж, 754 холбогдогчтой 456 хэргийн үлдэгдэлтэй гарав.


Шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн:

39.0 хувийг шүүгч дангаараа шийдвэрлэсэн

61.0 хувийг шүүх бүрэлдэхүүнээр шийдвэрлэсэн


Өнгөрсөн оноос шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 6.7хувиар, ял шийтгүүлэгсэд 4.9 хувиар өсчээ.

Шүүхээр 2004 онд шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо, ял шийтгүүлэгсдийг аймаг, нийслэлээр өмнөх онтой нь харьцуулж үзвэл:




Эрүүгийн хэрэг Говь-алтай, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Говьсүмбэр, Булган, Ховд, Нийслэл, Сэлэнгэ, Орхон, Хөвсгөл, Архангай, Увс, Хэнтий, Төв зэрэг 15 аймагт 2.8-29.3 хүртэл хувиар өсч, харин Өвөрхангай, Завхан, Дорноговь, Өмнөговь, Сүхбаатар, Баян-Өлгий, Баянхонгор зэрэг 7 аймагт 2.2-26.2 хүртэл хувиар буурчээ./Өсөлт, бууралтыг багаас ихрүү нь жагсаав./

## Ял шийтгүүлэгсдийг 2003 онтой харьцуулбал:



Ял шийтгүүлэгсэд Булган, Дорнод, Хэнтий, Сэлэнгэ, Нийслэл, Дархан уул, Ховд, Хөвсгөл, Увс, Орхон, Архангай, Төв аймагт 1.8- 50.8 хүртэл хувиар өсч, харин Завхан, Дорноговь, Өвөрхангай, Дундговь, Говь-Алтай, Сүхбаатар, Баянхонгор, Өмнөговь, Баян-Өлгий аймагт 6.0-51.0 хүртэл хувиар буурав.

## Шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн төрөл



- а. Онц хүнд гэмт хэрэг
- б. Хүнд гэмт хэрэг
- в. Хүндэвтэр гэмт хэрэг
- г. Хөнгөн гэмт хэрэг

## Түгээмэл гардаг эрүүгийн хэрэг

Хүнийг санаатай алсан 253 гэмт хэрэгт 289 хүн	Танхайрсан 710 гэмт хэрэгт 1026 хүн
Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулсан 285 гэмт хэрэгт 301 хүн	Дээрмийн 95 гэмт хэрэгт 216 хвн
Бусдын эд хөрөнгийг хулгайлсан 2426 гэмт хэрэгт 4261 хвн	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг 496 гэмт хэрэгт 530 хвн
	Албан тушаалын 19 гэмт хэрэгт 28 хүн шийтгүүлсний дотор хахууль авсан 1 гэмт хэрэгт 5 хүн, хахууль өгсөн 2 гэмт хэрэгт 2 хүн, хахуулийг зуучилсан гэмт хэрэгт 1 хүн шийтгүүлжээ.

Эдгээр төрлийн гэмт хэрэг нь шийдвэрлэсэн нийт хэргийн 68.0 хувь, ял шийтгүүлэгсдийн 69.0 хувийг эзэлж байна. Харин хулгай, танхайн гэмт хэргийн нийлбэр нь дангаараа 50.0 хувийг нь эзэлжээ.

Бусдыг санаатай алсан гэмт хэрэг өнгөрсөн оныхоос 44.5 хувиар, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 11.0 хувиар, хулгайн гэмт хэрэг 8.1 хувиар, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулсан гэмт хэрэг 6.7 хувиар өсч, харин танхайн гэмт хэрэг 16.7 хувиар буурсан байна.

Ял шийтгүүлэгсдийн 1121 буюу 11.8 хувь нь насанд хүрээгүй хүмүүс, 735 буюу 7.7 хувь нь эмэгтэйчүүд байгаагаас гадна 2065 буюу 21.8 хувь нь урьд ял шийтгүүлсэн, 1818 буюу 19.2 хувь нь гэмт хэрэг бүлэглэж үйлдсэн, 2228 буюу 23.5 хувь нь согтуугаар гэмт хэрэг үйлджээ.

Түүнчлэн 29 хүн буюу 0.3 хувь нь гадаадын харъяат, 73.6 хувь буюу 6977 нь ажил, сургуульгүй хүмүүс байна.

Гэмт хэргийн улмаас 592 хүний амь нас хохирч, 550 хүний биед хүнд, 648 хүний биед хүндэвтэр, 1176 хүний биед хөнгөн гэмтэл учирч, нийтдээ 5 тэрбум 10 сая төгрөгийн хохирол учирснаас иргэдэд 2 тэрбум 525 сая төгрөгийн; улсад 2 тэрбум 97 сая төгрөгийн; аж ахуйн нэгжид 578 сая төгрөгийн хохирол учирчээ. Шүүхийн шатанд 438 сая төгрөгийн хохирлыг барагдуулсан байна.

Шүүхээс оногдуулсан ял шийтгэлийн байдлыг авч үзвэл:

Д/д	Төрөл	Бүтэн жилд		Нийт ялын дотор эзлэх хувь	
		2003 он	2004 он	2003 он	2004 он
	Нийт ял шийтгүүлэгсэд	<b>9029</b>	<b>9473</b>		
<b>1</b>	Хорих ялаар бүгд Үүнээс:	<b>6561</b>	<b>6686</b>	72.7	70.6
	а/ Хорих ялыг эдлүүлсэн	2869	2926		
	б/ Ялыг тэнсэж хянан харгалзсан	2794	2886		
	в/ Эрүүгийн хуулийн 62, 63-р зүйлээр шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан Үүнээс:	883	858		
	а/Насанд хүрээгүй этгээд	835	784		
	б/Жирэмсэн эмэгтэй 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг	48	74		
	г/ Өршөөл, уучлал үзүүлсэн	15	16		
<b>2</b>	Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн	<b>2446</b>	<b>2661</b>	27.1	28.1
	а/ Торгуулийн ял	675	672		
	б/ Албадан ажил хийлгэх ял	271	396		
	в/ Баривчлах ял	1492	1593		
<b>3</b>	Онцгой ял	<b>22</b>	<b>22</b>	0.2	0.2
<b>4</b>	Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ	<b>8</b>	<b>104</b>		1.1

Шүүх эд хөрөнгө хураах нэмэгдэл ялыг 78 хүнд хэрэглэж, тэднээс 49 сая төгрөг гаргуулсны дээр, тодорхой албан тушаал эрхлэх буюу, тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах шийтгэлийг 451 хүнд нэмэгдэл ялын чанартайгаар оногдуулжээ.


Ял шийтгүүлэгсдийн 47.7 хувьд хорих ялыг биечлэн болон баривчлах ялаар шийтгэжээ.

Хорих ялын биечлэн эдлүүлэлэх болон баривчлах ялын улсын дундаж хувь, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулсан гэмт хэрэгт 88.7 хувь, хулгайн


гэмт хэрэгт 47.9 хувь, танхайн гэмт хэрэгт 33.7 хувь, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт 31.0 хувь, байна.

Шүүх 6686 хүнд оногдуулсан хорих ялын 82.7 хувийг жирийн, 13.8 хувийг чанга, 3.3 хувийг онцгой, 0.2 хувийг гяндангийн дэглэмд эдлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Давж заалдах шатны шүүхүүд эрүүгийн 1945 хэрэг хүлээн авч, 1888 хэргийг хянан шийдвэрлэж, түүнийхээ 51.5 хувийн тогтоолыг хэвээр үлдээж, 22.2 хувьд өөрчлөлт оруулж, 26.3 хувь буюу 497 тогтоолыг хүчингүй болгосон байна. Оны эцэст 57 хэргийн үлдэгдэлтэй гарав.



Хяналтын шатны шүүх эрүүгийн 858 хэрэг хүлээн авснаас, 241 хэргийг хянаж хариу өгсөн ба 592 хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж, оны эцэст 25 хэргийн үлдэгдэлтэй гарав. Хяналтын шатны шүүхээр хянан хэлэлцэгдсэн эрүүгийн хэргийн шийтгэх тогтоол, магадлалын 47.5 хувийг хэвээр үлдээж, 17.9 хувийг өөрчилж, 26.2 хувийг хүчингүй болгожээ.



Тайлангийн хугацаанд улсын хэмжээгээр анхан шатны шүүхээр эрүүгийн нийт 6272 хэргийг шийдвэрлэснээс давж заалдах болон хяналтын шатны шүүх 1155 шийтгэх тогтоолыг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хэргийнхээ 18.4 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ үзүүлэлт өмнөх оны түвшиндээ байна.


## ХОЁР. ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮН ТАСЛАХ АЖЛЫН ТАЛААР

Монгол улсын шүүхүүд иргэний 34758 нэхэмжлэл, өргөдөл хүлээн авч, - өргөдлийг хуульд заасан үндэслэлээр түдгэлзүүлэх буюу харъяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлжээ. Иргэний бүгд 23290 хэрэг шийдвэрлэсэн нь өмнөх оноос

117 хэргээр буюу 0.5 хувиар буурсан байна. Иргэний 2778 хэргийн үлдэгдэлтэй гарав.

Шийдвэрлэсэн нийт 23290 хэргийн 8623 буюу 37.0 хувийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74-р зүйлд заасан хялбаршуулсан журмаар, 14667 буюу 63.0 хувийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Харин 289 хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

Шийдвэрлэсэн иргэний хэргийг аймаг, нийслэлийн шүүхээр урьд онтой харьцуулбал:



Шийдвэрлэсэн иргэний хэрэг Завхан, Дорнод, Өвөрхангай, Орхон, Дархан-Уул, Төв, Сэлэнгэ, Дундговь, Булган, Хэнтий, Сүхбаатар, Архангай зэрэг 12 аймагт 4.24-62.9 хүртэл хувиар нэмэгджээ. /Өсөлт, бууралтыг багаас ихрүү нь жагсаав./

Харин Нийслэл, Дорноговь, Баянхонгор, Хөвсгөл, Говьсүмбэр, Увс, Говь-Алтай, Ховд, Өмнөговь, Баян-Өлгий зэрэг 10 аймагт 0.3—34.0 хувиар буурсан байна.


Шийдвэрлэсэн иргэний хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл:

Эрх зүйн харилцааны төрөл	Бүтэн жилд		Нийт хэрэгт эзлэх хувь		Зөрүү /+/, -/
	2003 он	2004 он	2003 он	2004 он	
Нийт иргэний хэрэг .	23407	23290			
Иргэний эрх зүйн маргаан	<b>11177</b>	<b>10799</b>	47.8	46.4	-1.4
Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулиар	<b>4751</b>	<b>5870</b>	20.3	25.2	4.9
Гэр бүлийн эрх зүйн маргаан	<b>2777</b>	<b>2939</b>	11.8	12.6	-0.8
Хөдөлмөрийн эрх зүйн маргаан	<b>819</b>	<b>591</b>	3.5	2.5	-1.0
Бусад эрх зүйн маргаан Үүнээс:	<b>3883</b>	<b>3091</b>	16.6	13.3	-3.3
Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар	58	41			
Дампуурлын хуулиар	6	3			
Компаний тухай хуулиар		11			
Нийгмийн даатгалын багц хуулиар	242	122			


Патентийн хуулиар	9	2			
Зохиогчийн эрхийн тухай хуулиар	9	5			
Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуулиар	13	19			
Төрийн албаны тухай хуулиар	19	6			
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар	7	12			
Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулиар	596	473			

Нийт хэрэгт иргэний эрх зүйн маргаантай хэрэг 46.4 хувийг, гэр бүлийн эрх зүйн маргаантай хэрэг 12.6 хувийг, хөдөлмөрийн эрх зүйн маргаантай хэрэг 2.5 хувийг нь эзэлж байна.

Давж заалдах шатны шүүхүүд иргэний 1324 хэрэг хянан хэлэлцэж, анхан шатны шүүхийн шийдвэрийн 47.6 хувийг хэвээр үлдээж, 23.8 хувийг өөрчилж, 33.8 хувийг хүчингүй болгожээ.



Хяналтын шатны шүүх иргэний 953 хэрэг хүлээн авч, 238 -ыг хянан хариу өгч, 677 хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэж, шүүхийн уг шийдвэр, магадлалын 47.5 хувийг хэвээр үлдээж, 30.1 хувийг өөрчилж, 22.4 хувийг нь хүчингүй болгожээ. 38 хэргийн үлдэгдэлтэй байв.



Улсын хэмжээгээр иргэний бүгд 23290 хэрэг шийдвэрлэснээс давж заалдах болон хяналтын шатны шүүх 1118 шийдвэрийг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт шийдвэрлэсэн хэргийн 5.1 хувийг эзэлж, өмнөх оноос 0.2 хувиар буурчээ.

## **ГУРАВ. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮН ТАСЛАХ АЖЛЫН ТАЛААР**

Шинээр байгуулагдсан Захиргааны хэргийн шүүхүүд 516 нэхэмжлэл, өргөдөл хүлээн авч, 65.3 хувь буюу 337 нэхэмжлэлийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэлээр харъяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэн, захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлэх шаардлагыг хангуулахаар нэхэмжлэгчид нь буцааж, харин нийт нэхэмжлэлийн 28.1 хувь буюу 145 хэргийг эцэслэн шийдвэрлэсэн байна.

Оны эцэст 34 хэргийн үлдэгдэлтэй гарсны дотор хуульд заасан үндэслэлээр 1 хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, 8 хэргийн шүүх хуралдааныг хойшлуулж, 25 хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байна.

Шийдвэрлэсэн захиргааны хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл,

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулиар 5, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулиар 53, Төрийн албаны тухай хуулиар 7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар 6, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулиар 6, Газрын тухай хуулиар 20, Ашигт малтмалын тухай хуулиар 6, Татварын багц хуулиар 13 хэрэг шийдвэрлэжээ. Эдгээр 116 хэрэг нь нийт шийдвэрлэсэн захиргааны хэргийн 75.3 хувийг эзэлж байна.

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим давж заалдах шатны журмаар 44 хэрэг хүлээн авснаас 15 хэргийг хянан шийдвэрлэж, 29 хэргийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хянан шийдвэрлэсэн захиргааны 15 хэргийн 2-ыг нь шүүхийн тогтоолоор хянан хэлэлцүүлэхээс татгалзан, анхан шатны шүүхийн 4 шийдвэрийг хэвээр үлдээж, 4-т нь өөрчлөлт оруулж, 2 шийдвэрийг нь хүчингүй болгов.

Энэ онд хяналтын шатны шүүхээр захиргааны хэрэг шийдвэрлээгүй байна.

Улсын хэмжээгээр захиргааны 145 хэрэг шийдвэрлэснээс давж заалдах шатны шүүхээс 6 шийдвэрийг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт шийдвэрлэсэн хэргийн 4.1 хувийг эзэлж байна.

## **ДӨРӨВ. БУСАД АСУУДЛААР**


Монгол улсын шүүх захиргааны арга хэмжээ авахуулахаар шилжүүлж ирүүлсэн 12183 материалыг хүлээн авч, 56-г татгалзан буцааж, 932 хүнийг 9588.0 мянган төгрөгөөр торгож, 11199 хүнд баривчлах шийтгэл ногдуулав. Нийт 12127 хэрэг шийдвэрлэсэн байна.

Шүүх тайлангийн хугацаанд ялтныг хорих ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах тухай 2107 материалыг хянан хэлэлцэж, 72 санал дүгнэлтийг хэрэгсэхгүй болгож, 1480 хүнийг эдлээгүй үлдсэн ялаас нь тэнсэн суллаж, 35 хүнийг хорих ял эдлэхээс чөлөөлжээ.

2004 онд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58, 59 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 1355 материал хүлээн авч, 1268 сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгож, 87 сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзажээ.


Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлд зааснаар 3068 хүнийг сэжигтнээр, 3042 хүнийг яллагдагчаар цагдан хорьж, 203 хүнд цагдан хорих зөвшөөрөл олгохоос татгалзсан байна.

### Шүүхээс улсын төсөвт оруулахаар шийдвэрлэсэн мөнгөн дүн



Хяналтын шатны шүүхээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 39 сая төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгохоор шийдвэрлэсэн байна.

**Анхан шатны шүүхүүд нийт 53765** хэрэг, маргааныг шийдвэрлэсний дотор эрүүгийн **7021** хэрэг, иргэний **32028** хэрэг, захиргааны **482** хэрэг, захиргааны зөрчил **12127**, ялтныг ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах, үлдсэн ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих тухай **2107** хүсэлт, 7465 хүнд цагдан хорих зөвшөөрөл олгох тухай асуудал байна.



Монгол улсын шүүхүүд 10035 өргөдөл, гомдол хүлээн авснаас 9559 буюу 95.2 хувийг шийдвэрлэн зохих хариуг байгууллага, иргэдэд хүргүүлсэн ба одоо 476 өргөдөл, гомдолд ажиллагаа хийж байна.

Ийнхүү анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг өсч, ажлын ачаалал нэмэгдэж, анхан шат, хяналтын шатны шүүхийн нэг шүүгчийн оролцох шүүх хуралдааны тоо нэмэгдэж, 2004 оны эрүү, иргэний шүүн таслах ажлын чанарт зарим ахиц гарч эхэлсэн байна.

Улсын хэмжээнд шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн 13.1 хувь нь хөнгөн гэмт хэрэг, 86.9 хувь нь хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэг эзэлжээ. Өмнөх оноос хүнд хэргийн төрөл 2.1 хувиар өссөний дотор хүнийг санаатай алсан гэмт хэрэг 44.5 хувиар өсөөд байгаа нь эрүүгийн нөхцөл байдал хүндэрсэн болохыг харуулж байна.

Шинээр байгуулагдсан захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагааг зөв төлөвшүүлэх, түүний шийдвэрийг нийтэлдэг болох, шүүхүүдийг мэдээлэлийн нэгдсэн сүлжээнд холбох зэрэг асуудлыг хэрэгжүүлэх нь шүүн таслах ажлын чанар үр дүнд сайнаар нөлөөлөх болно гэж үзэж байна.

## **УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ**